



**МЭДЭЭЛЭЛ, ШУУДАН, ХАРИЛЦАА  
ХОЛБОО, ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2009 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 111

Улаанбаатар хот

**БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 8.4, Газрын даргын зөвлөлийн 2009 оны 09 дүгээр сарын 25-ны эргийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. “Монгол Улсад Интернет протоколд суурилсан телевизийн үйлчилгээ (IPTV)-г нэвтрүүлэхэд баримтлах чиглэл”-ийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Дээрхи баримтлах чиглэлийг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллахыг Харилцаа холбооны зохицуулах хороо /Б.Болдбаатар/-д зөвлөмж болгосугай.

Гурав. Баримтлах чиглэлийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс /А.Мөнхбат/-т даалгасугай.



ДАРГА

Ж.САНСАР

Мэдээлэл, шуудан, харилцаа  
холбоо, технологийн газрын даргын  
2009 оны 11/1 дугаар тушаалын хавсралт

## МОНГОЛ УЛСАД ИНТЕРНЕТ ПРОТОКОЛД СУУРИЛСАН ТЕЛЕВИЗ (IPTV)-ИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ НЭВТРҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

### 1. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү баримт бичиг нь Монгол Улсад интернет протоколд суурилсан телевизийн үйлчилгээг нэвтрүүлэхэд баримтлах үндсэн чиглэлийг тодорхойлно.

### 2. Үйлчилгээний ангилал, төрөл, стандарт

2.1. Интернет протоколыг ашиглан хөдөлгөөнт дүрс, дуу дамжуулах үйлчилгээг технологийн хувьд дор дурдсан төрлүүдэд хуваана. Үүнд:

Хүснэгт 1

	1. Ай-Пи ТВ үйлчилгээ	2. Интернэт ТВ үйлчилгээ	3. Интернэт видео үйлчилгээ
Хэрэглэгчид	Бүртгэлтэй хэрэглэгчид	Чөлөөтэй	Чөлөөтэй
Үйлчилгээнүүд	<ul style="list-style-type: none"> <li>• Video on Demand (VOD)</li> <li>• Live TV</li> <li>• Төрөл бүрийн интерактив үйлчилгээнүүд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Video on Demand (VOD)</li> <li>• Live TV</li> </ul>	Видео клип
Сүлжээ	Зохион байгуулагдсан IP суурьтай сүлжээ	Нийтийн интернэт, Peer to Peer сүлжээ	Нийтийн интернэт
Дүрсийн чанар	<ul style="list-style-type: none"> <li>• managed QoS</li> <li>• MPEG-2, MPEG-4, MSVC1</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• managed QoS</li> <li>• MPEG4</li> </ul>	Unmanaged QoS
Хүлээн авах төхөөрөмж	Тусгай хүлээн авагч(STB), ТВ, PC	PC	PC
Дүрсийн ялгарал	Телевизийн бүрэн дэлгэц хангах нягтралтай	Телевизийн бүрэн дэлгэцийн хангахуйц нягтралтай	Хангалтгүй
Агуулгатай холбоотой			

оюуны өмчийн эрх	Хамгаалагдсан (Мэргэжлийн хэмжээнд хийгдсэн агуулгууд)	Хамгаалагдсан (Мэргэжлийн хэмжээнд хийгдсэн агуулгууд)	Хамгаалагдаагүй (Хэрэглэгчийн үүсгэсэн агуулгууд)
------------------	---	---	--

2.2. Хүснэгт 1-ийн 2 ба 3-т заагдсан Интернэт ТВ ба Интернэт видео үйлчилгээ үзүүлэгчидэд тусгай зөвшөөрөл олгох шаардлагагүй.

2.3. Монгол Улсад интернет протоколд суурилсан телевизийн үйлчилгээг нэвтрүүлэхдээ Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага (ITU-T) аас батлан гаргасан зөвлөмж буюу ITU-T Y.1910 үндсэн стандартыг мөрдлөг болгоно.

**3. Үйлчилгээний хамрах хүрээ**

3.1. Интернет протоколд суурилсан телевизийн үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэхдээ дараахь байдлаар бүс нутгийн хуваарилалт хийнэ. Үүнд:

3.1.1 Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамарсан интернет протоколд суурилсан телевизийн сүлжээ байгуулах;

3.1.2 Тухайн хот, суурин газарт интернет протоколд суурилсан телевизийн сүлжээ байгуулах гэж хуваана.

**4. Үйлчилгээ эрхлэгчдийг шалгаруулах зарчим**

4.1. Монгол Улсад интернет протоколд суурилсан телевизийн үйлчилгээг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлнэ.

4.2. Монгол Улсад интернет протоколд суурилсан телевизийн үйлчилгээг эрхлэх эрхийг тухайн газар нутагт 4 хүртэл оператор компанид олгоно.

4.3 Энэхүү баримт бичгийн 3.1.1-д заасан эрхийг олгохдоо холбогдох хууль, тогтоомжийн дагуу уралдаант шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулна.

4.4 Энэхүү баримт бичгийн 3.1.2-т заасан эрхийг хоёр буюу түүнээс дээш өргөдөл гаргасан тохиолдолд уралдаант шалгаруулалтын аргаар үйлчилгээ эрхлэгчийг шалгаруулна.

4.5 Монгол Улсад интернет протоколд суурилсан телевизийн үйлчилгээг нэвтрүүлэхдээ хот суурин газраас хөдөө орон нутгийг чиглэсэн хэлбэрээр нэвтрүүлнэ.

**5. Үйлчилгээ эрхлэгчидэд тавигдах нөхцөл шаардлага**

5.1. Интернет протоколд суурилсан телевизийн үйлчилгээ эрхлэгч нь дараах шаардлагыг хангасан үйлчилгээг заавал хүргэнэ. Үүнд:

- 5.1.1. Интернет протоколд суурилсан телевизийн үйлчилгээ эрхлэгч нь үйлчилгээний чанарыг хангахуйц зохион байгуулагдсан (managed) Интернет протоколд суурилсан сүлжээ ашиглах;
  - 5.1.2. Интернет протоколд суурилсан телевизийн дамжууллын системийн талаар олон улсын болон үндэсний стандартыг бүрэн хангасан тоног төхөөрөмж ашиглах;
  - 5.1.3. Тухайн үйлчилгээ үзүүлж буй хот суурин газрын хүн ам шигүү суурьшсан нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан байх;
  - 5.1.4. Хэрэглэгчид телевизийн нэвтрүүлгүүдийг хугацааны хожимдолгүй, тасалдалгүй, дуу дүрсний доголдолгүй хүлээн авах;
- 5.2. Интернет протоколд суурилсан телевизийн үйлчилгээ эрхлэгч нь дараах нөхцөл шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 5.2.1. Телевизийн нэвтрүүлгийг тасралтгүй түгээх, дамжуулах техник технологийн бололцоогоор бүрэн хангагдсан байх;
  - 5.2.2. Өөрийн техник, тоног төхөөрөмжинд байнгын хэмжилт, шалгалт хийх хэмжүүрийн техник хэрэгслээр хангагдсан байх;
  - 5.2.3. Нийт ажиллагсадын 30-аас доошгүй хувийг мэргэжлийн инженер техникийн ажиллагсад байхаар боловсон хүчний чадавхийг бүрдүүлсэн байх;
- 5.3. Монгол Улсын хэмжээнд интернет протоколд суурилсан телевизийн бүрэн сүлжээ байгуулан ажиллуулах хуулийн этгээдэд мөрдөгдөж буй хууль, эрх зүйн хэмжээнд үйл ажиллагаа явуулах шаардлага тавина.

**6. Бусад**

- 6.1. Энэхүү баримтлах чиглэлийг техник, технологийн хөгжил дэвшлийн дагуу тухай бүр өөрчилж болно.

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_

